



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянлиг сумын ОНХС-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2026/003/НА-СТА-ОНТС

<p>Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2026.02.25</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: Munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: М.Алтантуяа Утас: 99061829 Цахим хаяг: Altantuyam@audit.gov.mn Аудитор: А.Адилзаяа Утас: 80870886 Цахим хаяг: Adilzayaa@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	3
2. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	5
2.1 Зөвлөмж	5
2.2 Албан шаардлага	5
3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	6
4.ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ	6

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан

1.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

1.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	820,099,090.88	1,121,819,540.88
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	777,010,047.88	598,977,608.38
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	777,010,047.88	598,977,608.38
3121	Төгрөг	777,010,047.88	598,977,608.38
31211	Төрийн сангийн харилцах	777,010,047.88	598,977,608.38
33	АВЛАГА	4,089,000.00	-
335	Бусад авлага	4,089,000.00	-
3351	Байгууллагаас авах авлага	4,089,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	39,000,043.00	522,841,932.50
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	39,000,043.00	522,841,932.50
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	820,099,090.88	1,121,819,540.88
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	820,099,090.88	1,121,819,540.88
51	Засгийн газрын хувь оролцоо	820,099,090.88	1,121,819,540.88
512	Хуримтлагдсан үр дүн	820,099,090.88	1,121,819,540.88
51210	Өмнөх үеийн үр дүн	437,523,416.88	820,099,090.88
51220	Тайлант үеийн үр дүн	382,575,674.00	301,720,450.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	820,099,090.88	1,121,819,540.88

1.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,197,589,430.00	800,256,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	330,552,930.00	23,558,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	330,552,930.00	23,558,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	330,552,930.00	23,558,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	128,355,250.00	23,558,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	202,197,680.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	867,036,500.00	93,687,100.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	-	683,011,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	103,469,000.00	93,687,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	103,469,000.00	93,687,100.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	763,567,500.00	-
1330	Төсвийн захирагчдаас	763,567,500.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	815,013,756.00	498,536,350.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	815,013,756.00	498,536,350.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	815,013,756.00	498,536,350.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,440,500.00	-
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	10,440,500.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	804,573,256.00	498,536,350.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	804,573,256.00	498,536,350.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	382,575,674.00	301,720,450.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	382,575,674.00	301,720,450.00

1.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,197,589,430.00	800,256,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	330,552,930.00	23,558,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	330,552,930.00	23,558,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	330,552,930.00	23,558,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	128,355,250.00	23,558,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	202,197,680.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	867,036,500.00	776,698,800.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	-	683,011,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	867,036,500.00	93,687,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	103,469,000.00	93,687,100.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	763,567,500.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1,197,589,430.00	800,256,800.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	840,662,299.00	978,289,239.50
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	840,662,299.00	978,289,239.50
2200	Дотоод эх үүсвэрээр	840,662,299.00	978,289,239.50
220001	Барилга байгууламж	840,662,299.00	-
223001	Бусад хөрөнгө	-	978,289,239.50
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(840,662,299.00)	(978,289,239.50)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	356,927,131.00	(178,032,439.50)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	420,082,916.88	777,010,047.88
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	777,010,047.88	598,977,608.38

1.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөгөөр/	
					Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	820,099,090.88	00.00	820,099,090.88
D01	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	820,099,090.88	00.00	820,099,090.88
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	820,099,090.88	00.00	820,099,090.88
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	301,720,450.00	00.00	301,720,450.00
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	1,121,819,540.88	00.00	1,121,819,540.88

1.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

ЭЗА	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,558,810,200.00	978,289,239.50	580,520,960.50	62.76
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	693,807,200.00	683,011,700.00	10,795,500.00	98.44
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	693,807,200.00	683,011,700.00	10,795,500.00	98.44
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	97,424,500.00	93,687,100.00	3,737,400.00	96.16
132001	Орон нутгийн төсвөөс	97,424,500.00	93,687,100.00	3,737,400.00	96.16
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	767,578,500.00	201,590,439.50	565,988,060.50	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	23,558,000.00	(23,558,000.00)	
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	767,578,500.00	178,032,439.50	589,546,060.50	23.19
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,558,810,200.00	978,289,239.50	580,520,960.50	62.76
2200	Дотоод эх үүсвэрээр	1,558,810,200.00	978,289,239.50	580,520,960.50	62.76
223001	Бусад хөрөнгө	1,558,810,200.00	978,289,239.50	580,520,960.50	62.76
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	766,079,900.00	777,010,047.88	(10,930,147.88)	101.4
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	766,079,900.00	598,977,608.38	167,102,291.62	78.19

2. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 26,000.0 мянган төгрөгийн 2 зөрчил¹ илэрсэнд 10,000.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж, 16,000.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлэв

2.1 Зөвлөмж

2.1.1 Сумын ИТХ-ын 2025 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн 7/01 дугаар тогтоолоор "Зэвсэгт хүчний 103-р тусгай ротын албан хаагчид онцгой нөхцөл байдалд ажиллахад зориулсан хөдөлмөр хамгаалал аюулгүй байдлын хувцас нийлүүлэх" төсөл арга хэмжээг баталсан байна.

Энэ нь Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 4.4 дэх "Сум дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хууль болон энэхүү журмын хориглосон заалтад тусгаагүй дарах чиг үүргийн хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлнэ" гэсэн заалтад нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн баталж, хэрэгжүүлж байх, биелэлтийг нотлох баримтын хамт 2026 оны 10 дугаар сарын 15-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх зөвлөмж хүргүүлэв.

2.2 Албан шаардлага

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

2.2.1 Сумын ИТХ-ын 2025 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 7/01 дугаар тогтоолоор баталсан "Ламын гэгээний улаан тэмээний үүлдэр батлуулах" төсөл арга хэмжээний хүрээнд иргэн Б.Батхолбоотой 16,000.0 мянган төгрөгийн баримтат нэвтрүүлэг гүйцэтгэх гэрээ байгуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйл 15.1 дэх "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно" 15.1.4 дэх "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчилан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчилах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийн таслан зогсоох, цаашид Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хязгаарлалттай холбоотой арга хэмжээг баталж, санхүүжүүлэхгүй байх, биелэлтийг нотлох баримтын хамт Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 10 дугаар сарын 15-ны дотор ирүүлэх албан шаардлага хүргүүлэв.

3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Сумын ИТХ-ын 2025 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн 7/01 дугаар тогтоолоор "Зэвсэгт хүчний 103-р тусгай ротын албан хаагчид онцгой нөхцөл байдалд ажиллахад зориулсан хөдөлмөр хамгаалал аюулгүй байдлын хувцас нийлүүлэх" төсөл арга хэмжээг баталсан байна.	1	10,000.0					1	10,000.0
Сумын ИТХ-ын 2025 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 7/01 дугаар тогтоолоор баталсан "Ламын гэгээний улаан тэмээний үүлдэр батлуулах" төсөл арга хэмжээний хүрээнд иргэн Б.Батхолбоотой 16,000.0 мянган төгрөгийн баримтат нэвтрүүлэг гүйцэтгэх гэрээ байгуулсан байна	1	16,000.0			1	16,000.0		
Дүн	2	26,000.0			1	16,000.0	1	10,000.0

4. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Баянлиг сумын ОНХС-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	6	7	8	9
1	ТШЗ			1					
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ			1					

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 140/105-71288/БНА-2026/003
НА-СГА-ТМБ

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянлиг сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сумын ИТХ-ын 2025 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 7/01 дугаар тогтоолоор баталсан "Ламын гэгээний улаан тэмээний үүлдэр батлуулах" төсөл арга хэмжээний хүрээнд 16,000,000 (Арван зургаан сая) төгрөгийн баримтат нэвтрүүлэг гүйцэтгэх гэрээ байгуулж, хүлээн авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйл 15.1 дэх "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно" 15.1.4 дэх "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан

8426630394

/documents/2026 он/1. бичиг
хэрэг/тоот/4. албан шаардлага 2026.docx

гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Зөрчлийг таслан зогсоох, цаашид Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хязгаарлалттай холбоотой арга хэмжээг баталж, санхүүжүүлэхгүй байх, зөрчлийг арилгасан талаарх нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянлиг сумын Засаг дарга С.Энхзул, нягтлан бодогч С.Мөнхцэцэг нарт даалгав^{1,2}.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН³:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.МӨНХБАТ

АУДИТОР:



6417143544
БҮЯАНГОР 9007423

А.АДИЛЗАЯА

¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 “Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана.”

² Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 5.5 “Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй”

³ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно